**БАТЛАВ: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ЭНХМӨНХЧУЛУУН**

# ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

# ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

## *"БАГАНУУР" ХК-ИЙ "УУЛ-110/6КВ-ЫН ДЭД СТАНЦЫГ ШИНЭЭР БАРИХ, ХУУЧИН СТАНЦЫГ БУУЛГАЖ ТОНОГЛОЛ ШИЛЖҮҮЛЭХ" АЖЛЫН*

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БА ШААРДЛАГУУД

*Энэ хэсэгт ажил гүйцэтгэх хуваарь, техникийн тодорхойлолт, схем зураг, ажилтай холбогдолтой нэмэлт мэдээлэл, тоног төхөөрөмжийн зүгшрүүлэлт тохируулга, технологийн процессын зүгшрүүлэлтийн ажилланд тавигдах болон тоног төхөөрөмжийн шаардлага зэрэг мэдээллийг оруулав.*

1. Энэхүү ажлыг түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр батлагдсан зураг төсвийн дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгнө.
2. Зарим тоног төхөөрөмж, материалын техникийн үзүүлэлтийг тодорхойлоход ашигласан худалдааны тэмдэг, нэршил нь зөвхөн жишиг болгон, техникийн үзүүлэлтийн түвшинг тодорхой харуулах зорилгоор ашигласан болно. Тендерт оролцогч тухайн худалдааны нэр, тэмдэгтэй холбоотой үзүүлэлттэй дүйцэхүйц эсхүл илүү үзүүлэлт бүхий материал, тоног төхөөрөмж санал болгоно.

### ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэ бүлэгт Улаанбаатар, Багануур дүүрэгт бариглах үг байгууламжийн техникийн тодорхойлолт, зураг төсөл, ажил гүйцэтгэх болон хангах нийлүүлэх барааны шаардлага, ажилтнуудын болон тоног төхөөрөмжид тавих шаардлагуудыг багтаасан.

Багануур ХК-ийн нутаг дэвсгэр дээр бариглах уг байгууламжийн барилга угсралт болон тоног төхөөрөмж нийлүүлж, суурилуулах ажлын техникийн тодорхойлолтыг захиалагчийн тавьсан шаардлагад нийцүүлэн, тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болгон товч тодорхой байх зарчмаар бэлтгэв.

Тодорхойлолтыг бэлтгэхдээ өрсөлдөөнийг өрнүүлэх, худалдан авах бараа, материалын шинж чанар, материал, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааны шаардлага хангасан Монгол улсын болон олон улсын стандартуудын ISO шаардлагыг үндэс болгов.

Уулын дэд станцын бүх бараа материал, тоног төхөөрөмж нь үйлдвэрээс гарсан шинэ, хамгийн хэмнэлттэй (эрчим хүч) орчин үеийн шаардлага хангасан бүтээгдэхүүнүүд байна.

Уулын дэд станцын барилга байгууламжуудыг зорнулалт, хийцийн онцлог болон тэдгээрийн ижил төстэй байдлаар нь нэгтгэж техникийн ерөнхий тодорхойлолт ба шаардлагыг боловсруулсан ба тоног төхөөрөмжийн ялангуяа гадаад орноос хангаж нийлүүлэх шаардлагатай тоног төхөөрөмж бүрийн техникийн тодорхойлолт ба шаардлагыг тусгав.

Гэрээнд өөрөөр заагаагүй бол тодорхойлолтод дурдсан нийлүүлэгдэх бараа, материал болон хийгдэх, эсхүл турших ажлын стандарт, кодыг уг стандарт буюу кодын тухайн үед мөрдөгдөж буй хувилбарт тодорхойлсноор хэрэглэнэ. Үндэсний стандарт, кодыг заасан тохиолдолд түүнтэй жишихүйц, эсхүл түүнээс илүү чанартай бусад стандарт, кодыг төслийн менежер хянаж, бичгээр зөвшөөрөл олгосон бол хүлээн зөвшөөрнө. Заасан стандарт болон санал болгосон хувилбарт стандартын хоорондын ялгааг нийлүүлэгч бичгээр тодорхойлон гаргах бөгөөд зөвшөөрлийг авахыг хүсэж байгаа өдрөөс 28-аас доошгүй хоногийн өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер эдгээр зөрүүг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд нийлүүлэгч бичиг баримтад заасан стандартыг хангах үүрэгтэй.

Гүйцэтгэгч тендерийн баримт бичигт заасан шаардлагыг хангасан бараа материал, тоног төхөөрөмжийг гадаад болон дотоодын зах зээлээс худалдан авч нийлүүлнэ. Нийлүүлж байгаа бараа материал, тоног төхөөрөмж нь үйлдвэрийн газрын хаяг, шошго тэмдэглээ, техникийн тодорхойлолттой байхаас гадна олон улсын стандартын